



**ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

**Албан тушаалын тодорхойлолтыг
батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 104 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын Захиргаа удирдлагын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Чанар хяналтын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Захиргаа удирдлагын газрын Хүний нөөцийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Чанар хяналтын газрын Ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Захиргаа удирдлагын газрын Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, тайлан, төлөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Хуулийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Хүний нөөцийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар хэвсгэлтээр тус тус баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газрын дарга (албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Жавхлан)-д даалгасугай.

ДАРГА

П.БАТБААТАР



Д/У 129/нв 2023.04.07

152301000166